

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖИЙН
11 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТ

2019 оны 12 дугаар сарын 02

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1	2019.05.31	2019.06.21	A/619	<p>Паркийн "Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв"-ийн барилгын зураг төслийн гүйцэтгэгчээр "Нутаг консалтинг" ХХК шалгарч, нийслэлийн ЗДТГ-тай гэрээ байгуулсан. "Нутаг консалтинг" ХХК-тай 2019.11.07-нд уулзалт зохион байгуулан зураг төсөл хийгдэх 1067 м2 газрыг танилцуулж, тус газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын тайлан буюу шаардлагатай материалаар ханган ажиллаж байна.</p> <p>Захиргаа, нэгдсэн үйлчилгээний барилгын зураг төслийн ажлын даалгаврыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас баталсан бөгөөд ажлын даалгаварт тусгагдсанаар паркийн "Үйлдвэрийн албан контор"-ын гэж нэрлэхээр болсон.</p> <p>Нутаг консалтинг компанийн удирдлага 2019.11.22-нд газар дээр ажиллан эскиз зургийг зөвшилцөн баталгаажуулж, уг барилгыг барих талбайн хөрсний бүтцийн шинжилгээ хийх зорилгоор 2 цооног өрөмдөж дээж авах ажлыг зохион байгуулахад хамтран ажилласан. Мөн Үйлдвэрийн конторын барилгын газарт байр зүйн зургийг хийсэн бөгөөд барилгын эскиз зургийг батлуулахаар Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газарт хүргүүлээд байна. Эскиз зураг батлагдсанаар техникийн нөхцөл авах ажлыг эхлүүлнэ.</p>
2	2019.05.31	2019.06.21	A/619	<p>"Санни трейд" ХХК-иас 2019.11.14-нд урьдчилсан байдлаар ирүүлсэн Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан"-тай танилцаж, шаардлагатай тодруулга өгөх зорилгоор паркийн инженерүүд уулзаж нэмэлт тодотгол хийж, Ерөнхий төлөвлөгөөг хүргүүлсэн.</p> <p>2019.11.28-нд эцсийн байдлаар Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг "Санни трейд" ХХК-иас ирүүлсэн бөгөөд гүйцэтгэлийн түвшин 100% байна.</p> <p>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-03 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам"-ын дагуу орон нутгийн иргэдэд танилцуулан иргэдийн нийтийн хурал, иргэдээр хэлэлцүүлэн санал авч тусгах шаардлагатай байдаг тул Багануур дүүргийн 5 хорооны Иргэдийн нийтийн хурлын төлөөлөгчид болон иргэдэд танилцуулан санал авах ажлын бэлтгэлийг хангаж байна.</p> <p>Мөн паркийн зүгээс тайланд өгөх саналаа боловсруулж байна.</p>
3	2019.10.11	2019.10.09	A/1054	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг хангаж, https://erp.ulaanbaatar.mn/ системийн дэд системүүдийн сургалтуудыг албан хаагчдад дахин явуулж, хэрэглээг дээшлүүлэн ажиллаж</p>

байна.

Үндсэн хөрөнгө бүртгэлийн дэд системд байгууллагын албан хаагч бүрийн эзэмшиж байгаа үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлийг оруулсан. Цаашид шилжилт хөдөлгөөнийг тухай бүр оруулж, хяналт тавьж ажиллахаар хариуцсан албан хаагчид үүрэг болгож, хөдөлмөрийн гэрээнд тусгасан.

<https://edoc.ulaanbaatar.mn/> дэд системийн ашиглалт:


Ирсэн бичиг	Хариугай бичиг	Хариугүй бичиг	Шийдвэрлэлт, хувь		Хугацаа
			Хариугай	Хариугүй	
Захиргааны алба	3	10	100%	100%	5,23 хоног
Үйлдвэрлэл, технологийн алба	10	8	87,50%	90%	3,39 хоног
Нийт	13	18	93,75%	95%	4,31 хоног

Мөн дүүргээс зохион байгуулсан "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах аян"-ы хүрээнд хийсэн ажлын тайланг гаргаж 188 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

ТАНИЛЦСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН

ПАРК" ОНӨТҮГ-ЫН ДАРГА



ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МИЧИД-ЭРДЭНЭ